



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 01/41

Улаанбаатар хот

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 7.2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтнуудын бүтээмжээс хамаарч 2019 оны 09 дүгээр сарын ур чадварын нэмэгдлийг хуулийн дагуу олгосугай.
2. Ажлын бүтээмжийг Ур чадварын нэмэгдлийг дүгнэх журмын дагуу тооцон хавсралтаар батлуулахыг Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн дарга /Н.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу ур чадварын нэмэгдлийг олгохыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ц.Бямбасүрэн/-д зөвшөөрсүгэй.

